



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2024/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2024 оны 02 дугаар сарын 12

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.08.06 № 2/09

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь томилолтын хоногийг давхардуулан олгосон, даргад эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр шагнал олгосон нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны гүйцэтгэлийн

5020057

d:\2024 он\санхүүгийн тайлангийн аудит\ста\а4-албан тоот.docx

төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс 90.07 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>117,683,977.59</u>	<u>281,534,828.26</u>
33	АВЛАГА	2,827,000.00	2,827,000.00
335	Бусад авлага	2,827,000.00	2,827,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,827,000.00	2,827,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	114,856,977.59	278,707,828.26
351	Түүхий эд материал	45,675,810.46	162,073,416.96
35110	Тусгай зориулалттай материал	45,675,810.46	162,073,416.96
354	Хангамжийн материал	62,559,167.13	116,634,411.30
35410	Бичиг хэргийн материал	3,544,746.00	4,722,596.00
35420	Аж ахуйн материал	45,196,549.00	30,919,079.00
35430	Сэлбэг хэрэгсэл	115,000.00	115,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,861.13	1,057,510.30
35450	Барилгын засварын материал	304,425.00	244,425.00
35470	Бусад хангамжийн материал	13,394,586.00	79,575,801.00
35600	Мал амьтад	6,622,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>463,077,539.84</u>	<u>620,874,672.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	463,077,539.84	620,874,672.60
392	Биет хөрөнгө	408,167,539.76	566,484,672.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	349,700,950.00	381,450,950.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(56,495,641.96)	(72,399,551.63)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,550,727.00	212,010,527.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(140,265,035.64)	(133,013,651.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	132,701,047.51	144,429,847.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,091,397.92)	(99,998,036.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,243,995.85	31,833,216.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,437,542.90)	(24,551,122.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,483,854.78	151,146,193.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,223,416.96)	(24,423,700.08)
393	Биет бус хөрөнгө	54,910,000.08	54,390,000.12
39301	Програм хангамж	7,780,000.00	7,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,519,999.92)	(7,039,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,650,000.00	53,650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>580,761,517.43</u>	<u>902,409,500.86</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>580,761,517.43</u>	<u>902,409,500.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>580,761,517.43</u>	<u>902,409,500.86</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,909,074.85	330,634,074.85
51101	Өмч: - төрийн	(118,275,000.00)	330,634,074.85
512	Хуримтлагдсан үр дүн	164,314,044.68	485,962,028.11
51210	Өмнөх үеийн үр дүн	164,314,044.68	164,314,044.68
51220	Тайлант үеийн үр дүн		321,647,983.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,813,397.90	85,813,397.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>580,761,517.43</u>	<u>902,409,500.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	408,264,681.90	1,340,438,351.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,149,681.90	555,741,916.70
120	Нийтлэг татварын бус орлого	3,149,681.90	555,741,916.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,149,681.90	555,741,916.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00,000.00	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,049,681.90	55,706,916.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	325,115,000.00	784,696,435.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	93,117,500.00	676,016,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	93,117,500.00	76,016,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,997,500.00	108,680,435.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,499,500.00	26,200,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	18,279,997.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	54,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	3,042,976.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,498,000.00	6,657,462.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	437,825,956.43	1,018,605,868.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,825,956.43	1,018,605,868.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,143,910.44	992,087,737.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,931,360.81	424,782,942.66
210101	Үндсэн цалин	171,323,131.57	291,173,252.13
210102	Нэмэгдэл	33,404,500.24	90,178,224.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,894,000.00	11,402,009.00
210104	Урамшуулал	9,309,729.00	32,029,456.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,003,287.00	53,044,079.11
210201	Тэтгэврийн даатгал	18,526,077.07	36,109,967.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,179,535.67	4,250,125.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,743,628.52	3,400,220.75
210204	Ажилгүйдлийн даатгал	414,003.87	844,030.92
210205	Эрүүл мэндийн даатгал	4,140,041.87	8,439,734.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,055,200.00	13,300,962.21
210301	Гэрэл, цахилгаан	2,778,153.12	2,022,476.00
210302	Түлш, халаалт	11,932,798.88	9,133,696.21
210303	Цэвэр, бохир ус	2,344,248.00	2,144,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,823,587.10	80,798,820.14
210401	Бичиг хэрэг	7,640,150.00	4,377,350.00
210402	Тээвэр, шатахуун	7,369,171.90	29,889,523.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,298,999.20	2,303,620.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	598,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,810,406.00	26,026,340.00
210408	Бараа материал акталсны зардал	13,262,860.00	17,601,986.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	24,844,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,325,600.00	5,521,190.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	-	800,000.00
210604	Урсгал засвар	5,325,600.00	4,721,190.00
2107	Томилолт, зочны зардал	1,609,000.00	7,216,300.00
210702	Дотоод албан томилолт	1,609,000.00	7,216,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,924,990.00	146,657,827.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,121,500.00	139,773,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	168,100.00	10,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	504,300.00	247,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,592.00	604,792.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,740,000.00	4,784,000.00
210807	Газрын төлбөр	1,130,498.00	1,238,435.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,470,885.53	260,765,616.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,457,880.00	202,981,984.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,013,005.53	57,783,631.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,682,045.99	26,518,130.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,724,600.00	1,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,724,600.00	1,450,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,957,445.99	25,068,130.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,957,445.99	25,068,130.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>29,561,274.53</u>	<u>321,832,483.43</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,496,332.50	184,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,496,332.50	184,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,496,332.50)	(184,500.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(31,057,607.03)</u>	<u>321,647,983.43</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>325,215,000.00</u>	<u>784,731,435.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	325,115,000.00	784,696,435.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	293,117,500.00	676,016,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	293,117,500.00	676,016,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,997,500.00	108,680,435.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,499,500.00	26,200,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	18,279,997.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	54,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	3,042,976.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,498,000.00	6,657,462.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	323,132,300.00	772,968,435.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	323,132,300.00	772,968,435.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,450,254.01	746,450,304.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,882,377.81	424,836,356.92
210101	Үндсэн цалин	172,309,352.57	282,902,877.99
210102	Нэмэгдэл	33,404,500.24	99,646,964.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,894,000.00	11,402,004.40
210104	Урамшуулал	8,274,525.00	30,884,509.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,003,287.00	52,990,664.85
210201	Тэтгэврийн даатгал	18,526,077.07	36,056,552.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,179,535.67	4,250,125.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,743,628.52	3,400,220.75
210204	Ажилгүйдлийн даатгал	414,003.87	844,031.03
210205	Эрүүл мэндийн даатгал	4,140,041.87	8,439,734.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,055,200.00	13,300,962.21
210301	Гэрэл, цахилгаан	2,778,153.12	2,022,476.00
210302	Түлш, халаалт	11,932,798.88	9,133,696.21
210303	Цэвэр, бохир ус	2,344,248.00	2,144,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,645,499.20	19,585,320.31
210401	Бичиг хэрэг	2,904,300.00	3,719,200.00
210402	Тээвэр, шатахуун	5,293,600.00	12,109,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,298,999.20	2,303,620.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	598,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	550,600.00	853,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,425,600.00	9,639,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	800,000.00
210604	Урсгал засвар	5,425,600.00	8,839,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,609,000.00	7,216,300.00
210702	Дотоод албан томилолт	1,609,000.00	7,216,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,702,990.00	217,725,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,099,500.00	210,841,473.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	168,100.00	10,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	504,300.00	247,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,592.00	604,792.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	4,784,000.00
210807	Газрын төлбөр	1,130,498.00	1,238,435.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,126,300.00	1,155,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,126,300.00	1,155,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,682,045.99	26,518,130.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,724,600.00	1,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	1,724,600.00	1,450,000.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

	урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,957,445.99	25,068,130.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,957,445.99	25,068,130.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,082,700.00</u>	<u>11,763,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>2,082,700.00</u>	<u>11,763,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>2,082,700.00</u>	<u>11,763,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>2,082,700.00</u>	<u>11,763,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,082,700.00	11,763,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,082,700.00)</u>	<u>(11,763,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>00.00</u>	<u>00.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,909,074.85	85,813,397.90	195,371,651.71	0.00	730,094,124.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,909,074.85	85,813,397.90	195,371,651.71	0.00	730,094,124.46
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-118,275,000.00	0.00	0.00	0.00	-118,275,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-31,057,607.03	0.00	-31,057,607.03
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	164,314,044.68	0.00	580,761,517.43
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	164,314,044.68	0.00	580,761,517.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	164,314,044.68	0.00	580,761,517.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	321,647,983.43	0.00	321,647,983.43
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	485,962,028.11	0.00	902,409,500.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	676,016,000.00	657,640,331.29	18,375,668.71	97.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676,016,000.00	657,640,331.29	18,375,668.71	97.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	674,325,500.00	656,190,331.29	18,135,168.71	97.3

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,485,500.00	424,836,356.92	649,143.08	99.8
210101	Үндсэн цалин	276,170,400.00	282,902,877.99	(6,732,477.99)	102.4
210102	Нэмэгдэл	123,422,000.00	99,646,964.73	23,775,035.27	80.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,178,000.00	11,402,004.40	(1,224,004.40)	112.0
210104	Урамшуулал	15,715,100.00	30,884,509.80	(15,169,409.80)	196.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,186,700.00	52,990,664.85	196,035.15	99.6
210201	Тэтгэврийн даатгал	36,166,700.00	36,056,552.69	110,147.31	99.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,254,800.00	4,250,125.93	4,674.07	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,404,200.00	3,400,220.75	3,979.25	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	851,300.00	844,031.03	7,268.97	99.1
210205	Эрүүл мэндийн даатгал	8,509,700.00	8,439,734.45	69,965.55	99.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,066,600.00	13,300,962.21	765,637.79	94.6
210301	Гэрэл, цахилгаан	2,360,900.00	2,022,476.00	338,424.00	85.7
210302	Түлш, халаалт	9,134,100.00	9,133,696.21	403.79	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,571,600.00	2,144,790.00	426,810.00	83.4
2104	Хангамж, бараа материалын зардал	23,458,700.00	19,585,320.31	3,873,379.69	83.5
210401	Бичиг хэрэг	3,719,200.00	3,719,200.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,949,200.00	12,109,200.00	3,840,000.00	75.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,337,000.00	2,303,620.31	33,379.69	98.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	853,300.00	853,300.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,510,500.00	14,502,900.00	7,600.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,670,000.00	5,663,000.00	7,000.00	99.9
210604	Урсгал засвар	8,840,500.00	8,839,900.00	600.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,352,800.00	7,216,300.00	136,500.00	98.1
210702	Дотоод албан томилолт	7,352,800.00	7,216,300.00	136,500.00	98.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	134,732,500.00	122,602,827.00	12,129,673.00	91.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,858,200.00	115,718,500.00	11,139,700.00	91.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	82,300.00	10,000.00	72,300.00	12.2
210803	Даатгалын үйлчилгээ	247,100.00	247,100.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,448,200.00	604,792.00	843,408.00	41.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,400.00	-	49,400.00	-

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,800,000.00	4,784,000.00	16,000.00	99.7
210807	Газрын төлбөр	1,247,300.00	1,238,435.00	8,865.00	99.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,532,200.00	1,155,000.00	377,200.00	75.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,532,200.00	1,155,000.00	377,200.00	75.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,690,500.00	1,450,000.00	240,500.00	85.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,690,500.00	1,450,000.00	240,500.00	85.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,690,500.00	1,450,000.00	240,500.00	85.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	676,016,000.00	657,605,331.29	18,410,668.71	97.3
1320	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	676,016,000.00	657,605,331.29	18,410,668.71	97.3
122005	Улсын төсвөөс санхүүжих	676,016,000.00	657,605,331.29	18,410,668.71	97.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	24.00	24.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	102,022,973.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	102,022,973.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,022,973.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,022,973.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,022,973.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	102,022,973.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,022,973.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,200,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	18,279,997.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,042,976.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 56,478.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. ХХААХҮЯ-аас ирсэн 51,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий газар хагалдаг тракторыг машин, тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, ангилал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/559 дугаар аймгийн Онцгой комиссоос үнэ төлбөргүй олгосон 4,978.0 мянган төгрөгийн бараа, материалыг орлого авч бүртгээгүй нь УСНББОУС-12 Бараа материал, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 118,736.9 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 1,210.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 114,699.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2,827.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 4,037.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,097.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Даргын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн "Нийт албан хаагчдад урамшуулал олгох тухай" Б/28 дугаар тушаалаар дарга өөртөө шийдвэр гаргаж 122.5 мянган төгрөгийн шагнал авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд өөртөө шийдвэр гарган авсан 122.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Мэргэжилтэн Э.Бумбаяр нь 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хооронд сумдад томилолтоор ажиллах хугацаандаа 30 хоногийн томилолтын мөнгө авч 17 хоногийн 1,088.0 мянган төгрөгийн томилолтыг илүү авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4 “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, 2.8 “Томилолтын хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн тохиолдолд хэтрүүлсэн хугацааны байр, хоолны зардлыг олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын зардалд илүү авсан 1,088.0 мянган төгрөгийг холбогдох мэргэжилтнээр төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 106,533.2 мянган төгрөгийн 17 гэрээ байршуулахаас 85,533.2 мянган төгрөгийн 16 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 202,700.6 мянган төгрөгийн 39 тушаал байршуулахаас 102,409.8 мянган төгрөгийн 23 тушаалыг тус тус байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 759,364.5 мянган төгрөгийн 24 гүйлгээ мэдээлэхээс 68,000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 120,539.4 мянган төгрөгийн 12 гүйлгээ мэдээлэхээс 46,699.4 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй мал, ноолуур дутагдуулж байгууллагад хохирол учруулсан тул 2017 оны санхүүгийн тайланд малчнаас авах авлагыг 2,827.0 мянган төгрөгөөр тусгасан боловч авлагыг барагдуулаагүй байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг хууль, журмын хүрээнд барагдуулж, данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч, цаашид Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн	1	51,500.0	-	-	1	51,500.0	1	51,500.0	-	-
Санхүүгийн тайланд бүртгээгүй	1	4,978.0	1	4,978.0	-	-	1	4,978.0	-	-
Дүн	2	56,478.0	1	4,978.0	1	51,500.0	2	56,478.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Даргын 2023 оны Б/28 тушаалаар дарга өөртөө шийдвэр гаргаж 122.5 мянган төгрөгийн шагнал авсан байна.	1	122.5	1	122.5	-	-	-	-
Мэргэжилтэн Э.Бумбаярт 17 хоногийн 1,088.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон.	1	1,088.0	1	1,088.0	-	-	-	-
Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй мал, ноолуур дутагдуулж байгууллагад хохирол учруулсан тул 2017 оны санхүүгийн тайланд малчнаас авах авлагыг 2,827.0 мянган төгрөгөөр тусгасан боловч авлагыг барагдуулаагүй байна.	1	2,827.0	-	-	-	-	1	2,827.0
Дүн	3	4,037.5	2	1,210.5	-	-	1	2,827.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил									
Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 85,533.2 мянган төгрөгийн 16 гэрээ,	1	114,699.4	-	-	1	114,699.4	-	-	

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

102,409.8 мянган төгрөгийн 23 тушаалыг тус тус байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 68,000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 46,699.4 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.								
Дүн	1	114,699.4	-	-	1	114,699.4	-	-

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 2/A0571124
БНА-2024/09/НА-СТА-ТШЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Даргын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн "Нийт албан хаагчдад урамшуулал олгох тухай" Б/28 дугаар тушаалаар дарга өөртөө шийдвэр гаргаж 122,500 төгрөгийн шагнал авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр дарга өөр өөртөө шийдвэр гарган авсан 122,500 (нэг зуун хорин хоёр мянга таван зуу) төгрөгийг төсвийн

5050020

захирагчаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх¹


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга У.Балжинням, нягтлан бодогч Т.Уянга нарт даалгав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АУДИТОР:

Н.БАТЧИМЭГ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 8/А0571121
БНА-2024/09/НА-СТА-ТМБ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэжилтэн Э.Бумбаяр нь 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хооронд сумдад томилолтоор ажиллах хугацаандаа 30 хоногийн томилолтын мөнгө авч 17 хоногийн 1,088,000 мянган төгрөгийн томилолтыг илүү авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Томилолтын зардалд илүү олгосон 1,088,000 (нэг сая наян найман мянга) төгрөгийг холбогдох албан тушаалтантай тооцоо хийн төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх¹

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

5050025


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга У.Балжинням, нягтлан бодогч Т.Уянга нарт даалгав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БАТЧИМЭГ



² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 6/А05711921
БНА-2024/09/НА-СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 106,533.2 мянган төгрөгийн 17 гэрээ байршуулахаас 85,533.2 мянган төгрөгийн 16 гэрээ, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах 202,700.6 мянган төгрөгийн 39 тушаал байршуулахаас 102,409.8 мянган төгрөгийн 23 тушаалыг тус тус байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 759,364.5 мянган төгрөгийн 24 гүйлгээ мэдээлэхээс 68,000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 120,539.4 мянган төгрөгийн 12 гүйлгээ мэдээлэхээс 46,699.4 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан


5040018

зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасны дагуу 85,533.2 мянган төгрөгийн 16 гэрээ, 102,409.8 мянган төгрөгийн 23 тушаал, орлогын 68,000.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 120,539.4 мянган төгрөгийн 12 гүйлгээг бүрэн байршуулан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга У.Балжинням, нягтлан бодогч Т.Уянга нарт даалгав .

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН¹

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БАТЧИМЭГ



¹ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно